

ТАНИЛЦУУЛГА

Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг
хориглох тухай конвенцын нэмэлт протоколыг
соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

Нислэг үйлдэж байгаа агаарын хөлгийг булаан авах хууль бус үйлдэл нь иргэний нисэхийн аюулгүй байдалд ноцтой нөлөөлж байгаатай холбогдуулан ийм үйлдлийг таслан зогсоох, гэмт этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх олон улсын эрх зүйн хэм хэмжээг бэхжүүлэх зорилгоор 1970 оны 12 дугаар сарын 16-ны өдөр Нидерланд Улсын Гаага хотноо зохион байгуулсан Олон улсын агаарын эрх зүйн бага хурлаас баталсан "Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенц"-д Монгол Улс 1971 оны 10 дугаар сарын 08-ны өдөр нэгдэн орсон.

Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотноо 2010 онд зохион байгуулсан Нисэхийн аюулгүй байдлын талаарх олон улсын Дипломат бага хурлаас иргэний нисэхийн эсрэг шинэ төрлийн хууль бус үйлдлүүд дэлхий даяар нэмэгдэж байгааг онцлон "Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол"-ыг баталж, орхигдуулсан, зарим шаардлагатай зохицуулалтуудыг нэмж тусгасан.

"Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол" нь 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн бөгөөд нийт 35 улс гарын үсэг зурж, 21 улс соёрхон баталж, 21 улс нэгдэн орж, 1 улс хүлээн зөвшөөрч, 1 улс баталсан байна.

"Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол"-д ашиглалтад байгаа агаарын хөлгийг хууль бусаар булаан авах, хяналтаа тогтоох үйлдэл, оролдлого, оролцооны хэлбэр, хүлээлгэх хариуцлага, гэмт үйлдлийн хамрах хүрээ, харьяалал, ялын байдал, төрийн байгууллагаас авах арга хэмжээ, улс орнуудын хамтын ажиллагааны зохион байгуулалт зэргийг илүү нарийвчлан тодорхойлсон бөгөөд эдгээр гэмт хэргийг үйлдэхийг завдах, хамтран оролцох, хэрэг үйлдсэний дараа тухайн этгээдэд туслалцаа үзүүлэх зэрэг үйлдлийг гэмт хэрэгт багтаасан.

Мөн ашиглалтад байгаа агаарын хөлгийн хугацааг "газрын үйлчилгээний алба, эсхүл нислэгийн баг агаарын хөлгийн нислэгийн өмнөх бэлтгэлийг хангаж эхэлснээс хойш аливаа буулт хийсний дараа 24 цагийн хугацаанд" гэж уртасгасан, түүнчлэн гэмт хэргийн харьяалал тогтоохтой холбоотой нэмэлт заалтуудыг тусгасан.

Монгол Улс "Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенц"-ын оролцогч улсын хувьд агаарын тээврийн салбарын хурдацтай өсөлттэй уялдуулан иргэний нисэхийн аюулгүй байдлын стандартыг олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх зорилгоор "Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол"-ыг соёрхон батлах шаардлагатай юм.

Олон улсын гэрээний тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсэгт "Соёрхон баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Улсын

Их Хурал, баталсан олон улсын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийг Засгийн газар гаргана." гэж заасны дагуу "Агаарын хөлгийг хууль бусаар булаан авах үйлдлийг хориглох тухай конвенцын нэмэлт протокол"-ыг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Эрүүгийн хуулийн Тусгай ангийн 27 дугаар бүлгийн 27.8 дугаар зүйл, 27.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт өөрчлөлт оруулах шаардлагатай.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР